



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот


Төрийн албаны зөвлөлийн
Үндэсний статистикийн хорооны дэргэдэх
салбар зөвлөлийн нарийн бичгийн
даргыг томилох тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн хорооны Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Шаравсэнгийн Оюунгэрэлийг Төрийн албаны зөвлөлийн тус хорооны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Оюунгэрэлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦОГОО